



У.УУГАНБААТАР
Тэтгэлэгт хамрагдагч



ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Би бол Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Сангийн далай багийн иргэн. 2017 онд Сайншанд сумандаа бүрэн дунд боловсрол эзэмшээд Улаанбаатар хотноо Үндэсний биеийн тамирын их сургуульд суралцахаар ирсэн. Одоо

"Биеийн тамирын багш болоод сумандаа ажиллах хүсэлтэй."

3 дугаар курсэд суралцдаг. Манай аймагт үйл ажиллагаа эрхэлдэг "Бадрах Энержи" компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлдэг "Оюутны тэтгэлэг" хөтөлбөрт 2018-2020 оны хичээлийн жилүүдэд хамрагдсан. Санхүүгийн боломж, бололцоо тааруу ч мэргэжилтэй болъё гэсэн чин хүсэл эрмэлзэлтэй малчдын хүүхдүүдийг дээд боловсрол эзэмших нөхцөл бололцоогоор хангаж байгаад би болон манай гэр бүлийн зүгээс ихэд талархаж байгаа. Би биеийн тамирын багш болоод сумандаа ажиллах хүсэлтэй.

-У.Ууганбаатар

ЗОРИЛГО: Үйл ажиллагаа эрхэлж буй орон нутагт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, сурагчдын боловсролыг дэмжих, компанийн ирээдүйн мэргэжилтэнг орон нутгаас хангах.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: Тэтгэлэг бакалаврын сургалтын нийт хугацааг хамардаг. Хамрагдах хүсэлтэй оюутан сурагчид төгссөн сургууль, орон нутгийн удирдлагад хүсэлтээ гаргана. Хүсэлтийг хүлээн аваад орон нутгийн хамтарсан комисс тодорхой шалгуурын дагуу шалгаруулна. Сонгогдсон оюутнуудыг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдэд танилцуулж, саналыг авснаар тухайн оюутанд олгох тэтгэлэг баталгааждаг.



2010 оноос хойш хэрэгжиж буй уг хөтөлбөрт Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян багийн 39 оюутан хамрагдаж нийт 81 удаагийн тэтгэлэг олгоод байна.



Төслийн явцын тухай мэдээллийг бидний Фэйсбүүк хуудаснаас авна уу.
<https://www.facebook.com/badrakhenergy>